



МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Ойд арчилгааны огтлолт явуулах журам/

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 190

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Ойд арчилгааны огтлолт явуулах журам"-ыг 1 дүгээр, "Ойд цэвэрлэгээний огтлолт хийх журам"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү журам, зааврыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, мөрдүүлэн ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сумдын ойн ангийн удирдлага болон нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

Гурав. Журам, зааврын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар /М.Тунгалаг/ нарт даалгасугай.

Дөрөв. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам, заавар батлах тухай" Байгаль орчны сайдын 1997 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 166, "Журам батлах тухай" Байгаль орчны сайдын 2002 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 65, "Гэрчилгээний загвар шинэчлэн, журманд өөрчлөлт оруулах тухай" Байгаль орчны сайдын 2007 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 34 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л.ГАНСҮХ

Улсын бүртгэлд 2009 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 3061 дүгээрт бүртгэгдсэн

ОЙД АРЧИЛГААНЫ ОГТЛОЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ойн хэвийн өсөлт, хөгжилтийг хангах, бүтэц, бүрэлдэхүүн, таваарлаг чанарыг сайжруулах, хөнөөлт шавж, өвчин, түймрээс урьдчилан сэргийлэх, байгалийн аясаараа сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн ойн арчилгааны огтлолтыг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийг хүлээж авах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. "Ойн арчилгааны огтлолт" гэж зулзаган ойн титэм нийлэх үеэс эхлэн ашиглалтын нас хүртэлх хугацаанд түүний бүтэц, бүрэлдэхүүн, шигүүрлийг зохицуулж, модны өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор мод, сөөгийг үе шаттайгаар сонгон огтлох арга хэмжээг хэлнэ. Ойн арчилгааны огтлолт нь дараах хэлбэрт хуваагдана. Үүнд:

- Гэрэлжүүлэх
- Тохируулах
- Сийрэгжүүлэх
- Завсрын

1.2.1. "Гэрэлжүүлэх огтлолт" гэж шигүү ургасан зулзаган ой дахь гэрлийн хэмжээг нэмэгдүүлж, модны өсөлт, хөгжилтийг түргэтгэхийг;

1.2.2. "Тохируулах огтлолт" гэж өсвөр залуу модыг талбайд жигд тархан байрлахаар тохируулахыг;

1.2.3. "Сийрэгжүүлэх огтлолт" гэж залуу модны титэм, ишний хэлбэрийг сайжруулж, модны өндрийн өсөлтийг нэмэгдүүлэх тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэхийг;

1.2.4. "Завсрын огтлолт" гэж дунд насны модны өсөлтийг түргэтгэж, болцын насыг богиносгохыг;

1.3. Ойн арчилгааны огтлолтыг "Ойд арчилгааны огтлолт явуулах заавар"-ын дагуу гүйцэтгэнэ.

1.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн ойд явуулах арчилгааны огтлолтыг зөвшөөрөгдөх бүсүүдэд явуулах ба үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.5. Ойн арчилгааны огтлолтыг ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага болон ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Хоёр. Ойн арчилгааны огтлолтыг төлөвлөх

2.1. Ойн арчилгааны огтлолтыг төлөвлөхдөө доорх дарааллыг баримтлана.

2.1.1. Ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн арчилгааны огтлолт явуулах шаардлагатай талбайг сонгоно.

2.1.2. Арчилгааны огтлолт явуулах талбайн хэмжээ, огтлолтын хэлбэрийг тогтооно.

2.1.3. Арчилгааны огтлолт явуулах талбайг тусгаарлах ажлыг огтлолт явуулахаас нэг жилийн өмнө мод ногоорсон үед ойн мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.

2.1.4. Арчилгааны огтлолт явуулах талбайн хэмжээг Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2008 оны 89/35 тоот хамтарсан тушаалаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга

хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 2 дугаар зүйл мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 127 дугаар тушаалаар баталсан "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 2 дугаар зүйлд зааснаар арчилгааны огтлолтын хэлбэр тус бүрээр төлөвлөж, батлуулна.

Гурав. Ойн арчилгааны огтлолтыг зохион байгуулах

3.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллага нь гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолтыг гүйцэтгэхдээ тухайн аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай гэрээ байгуулж ажиллана. Өөрийн хөрөнгөөр сийрэгжүүлэх, завсрын арчилгааны огтлолтыг гүйцэтгэхдээ тухайн сум, дүүргийн Засаг даргатай "Мод бэлтгэх гэрээ" байгуулж ажиллана.

3.2. Ойд арчилгааны огтлолт явуулахад Засгийн газрын 1996 оны 312 тогтоолын 2 дугаар хавсралтанд заасны дагуу насны II анги хүртэлх ойд арчилгаа, тордолт хийхэд ойн нөөц ашигласны төлбөр төлөхгүй.

3.3. Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолтын нормативт зардлыг ажил гүйцэтгэгчид гэрээний дагуу 50 хүртэлх хувийг урьдчилан олгоно.

3.4. Сийрэгжүүлэх, завсрын арчилгаа явуулахдаа Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3-ыг мөрдлөг болгоно.

Дөрөв. Ойд арчилгааны огтлолт явуулах нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

4.1. Нөхөрлөл нь Ойн тухайн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3, аж ахуйн нэгж, байгууллага нь мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан үүргийг хүлээхийн зэрэгцээ дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

4.1.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолтыг ойн нас, арчилгааны зорилгоос нь хамааруулан хэлбэр бүрээр технологийн карт боловсруулж, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар; өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх сийрэгжүүлэх, завсрын арчилгааны огтлолтыг сум дундын болон сум, дүүргийн ойн ангийн даргаар тус тус батлуулна.

4.1.2. Ойн арчилгааны огтлолтыг гүйцэтгэгч нь ойд арчилгааны огтлолт явуулах зааврыг дагаж мөрдөнө.

4.1.3. Гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолтоос гарсан модыг ойн захад гаргаж хураана. Сийрэгжүүлэх, завсрын арчилгааны огтлолтоос гарсан модыг ангилан ялгаж борлуулна. Арчилгааны огтлолтын ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж, байгаль хамгаалагчид ойг хүлээлгэн өгнө.

4.1.4. Ойд арчилгааны огтлолт явуулсан ажлын тайланг сум дундын болон сум, дүүргийн ойн ангийн мэдээллийн санд оруулж баримтжуулна.

Тав. Ойд арчилгааны огтлолтын явцад тавих хяналт

5.1. Ойн арчилгааны огтлолтын явцад сум дундын болон сум, дүүргийн ойн анги болон аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг хяналт тавьж ажиллана.

5.2. Арчилгааны огтлолтын явцад байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч байнгын хяналт тавина.

5.3. Сийрэгжүүлэх, завсрын арчилгааны огтлолтоос гарсан хэрэглээний болон түлээний модыг "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 4.5-д заасны дагуу хяналтын хуудсаар тээвэрлэхэд байгаль хамгаалагч хяналт тавина.

5.4.Ойн арчилгааны огтлолтын явцад нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь Ойн тухай хууль, тогтоомж, журам, зааврыг зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хуулийн дагуу байгаль орчны хяналтын улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулна.

Зургаа. Арчилгааны огтлолтын гүйцэтгэлийг шалгах, хүлээн авах, тайлагнах

6.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолтын явцад шехнологийн хяналт тавих, мэргэжлийн туслалцаа үзүүлэх ба гүйцэтгэлийг шалган хүлээн авахдаа дараах шалгуурыг баримтлана. Үүнд:

6.1.1. Арчилгааны огтлолт явуулах ойг зөв сонгосон, огтлох модны сонголт, гэмтлийн байдал, тооллого, тэмдэглэл, ойн өтгөрөл технологийн картад заасантай тохирч байгаа, талбай тусгаарласан байдлыг шалгаж, ажлын чанарт үнэлгээ өгнө.

6.1.2. Арчилгааны огтлолт явуулсан нийт талбайн 2 хувиас багагүй жишиг талбай байгуулж, шалгах тооллого хийж, үлдээсэн модыг зөв сонгосон, модыг хэрэглээ, түлээнд зөв ангилсан, тоолсныг шалгана.

6.1.3. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь технологийн картад насны 1-11 ангийн ойд титэм битүүрлийг $+0.1$ нэгжээс хэтрүүлэхгүй, насны II ангиас дээш ойд төлөвлөсөн огтлогдох моддын хөндлөн огтлолын талбайн нийлбэрээс $+10$ хувиас хэтрүүлэхгүй байх.

6.1.4. Энэ журмын 6.1.3-д заасан шалгуурын үзүүлэлтийг дутуу хангасан бол нөхөн гүйцээх, хэтрүүлсэн бол Ойн тухай хуулийн 38.2.6-д зааснаар захиргааны шийтгэл ногдуулна.

6.2.Ойн гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолтыг гүйцэтгэгч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ажлын гүйцэтгэлийг гаргаж, холбогдох аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай байгуулсан гэрээнд заасан хугацаанд тайланг хүргүүлнэ.

6.3.Ойд гэрэлжүүлэх, тохируулах арчилгааны огтлолт явуулсан ажлын гүйцэтгэлийг шалгаж, хүлээн авсан ажлын хэсгийн актыг үндэслэн холбогдох аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар улс, орон нутгийн төсвөөс эцсийн санхүүжилтийг олгоно.

6.4.Эцсийн санхүүжилтийг олгохдоо арчилгааны огтлолтын талбайн хэмжээг гэрээнд зааснаас дутуу гүйцэтгэсэн тохиолдолд нормативт зардлыг хувь тэнцүүлэн бууруулж, санхүүжүүлнэ.

6.5.Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ойн арчилгааны огтлолтыг сум дундын болон сум, дүүргийн Ойн анги шалгаж, хүлээн авахдаа энэ журмын 6.1.1-6.1.3 заалтыг баримтална.

-----oOo---

ОЙД ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ОГТЛОЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж хатсан, цаашид ургах чадваргүй болсон ойг цэвэрлэж, модыг ашиглах, ойн байгалийн аясаараа нөхөн сэргэх нөхцөлийг хангах, ой модыг эрүүлжүүлэхэд чиглэгдсэн цэвэрлэгээний огтлолтыг ойн экологид сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр зохион байгуулах, төлөвлөх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2."Ойн цэвэрлэгээний огтлолт" гэж түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, байгалийн нөлөөгөөр хугарч гэмтсэн, булгарч унасан, хатсан, унанги болон нас гүйцэж хөгширсөн, өсөлт хөгжилт нь зогсож өмхөрсөн модыг бэлтгэж ойг цэвэрлэх, ашиглах зорилгоор бүх насны ойд хийгдэх ажлыг хэлнэ.

1.3.Ойн цэвэрлэгээний огтлолтыг дараах ойд явуулна. Үүнд:

- Түймэрт шатсан;
- Хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн;
- Байгалийн гамшгийн нөлөөгөөр хугарч гэмтсэн, булгарч унасан, хатсан, унанги ойд;
- Өсөлт хөгжилт нь зогсож өмхөрсөн болон нас гүйцэж хөгширсөн;

1.4.Ойд хийх цэвэрлэгээний огтлолтыг Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт зааснаар ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага болон мэргэжлийн байгууллага. гүйцэтгэнэ.

Хоёр. Түймэр, хөнөөлт шавж өвчинд нэрвэгдсэн, өсөлт зогссон ойд дүгнэлт гаргах, модыг ашиглах

2.1. Сум, дүүрэг болон ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, өсөлт зогссон ойн чанар, шинж байдалд мэргэжлийн байгууллага, сум дундын болон сум, дүүргийн ойн анги дүгнэлт гаргана.

2.2.Ойн мэргэжлийн байгууллага нь ойн цэвэрлэгээний огтлолт явуулах талбайг тусгаарлах ажлыг "Ойгоос мод бэлтгэлийн а?албайг тусгаарлах заавар"-ын дагуу гүйцэтгэнэ.

2.3.Ойн түймрийн шаталтын сул, дунд зэрэглэлд орсон ойгоос хатсан ба амьдрах чадвараа алдсан модыг түүвэрлэх; хүчтэй зэрэглэлд хамрагдсан болон иш, холтос, модолгийн хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойд ойн нөөцийн 60 хүртэл хувьд цэвэрлэгээний огтлолтыг явуулна.

2.4.Түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойд цэвэрлэгээний огтлолт явуулахад ойн экологийн байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй, өсвөр модыг хамгаалах технологийг сонгоно. Огтлох том модыг үндэсний хүзүү орчимд тэмдэглэнэ. Зулзаган ойд хийх цэвэрлэгээний огтлолтыг нүдэн баримжаагаар шалгаж хүлээж авна.

2.5.Ойн цэвэрлэгээ ний огтлолтоос гарсан модыг ялган, хэрэглээний ба түлээний гэж ангилна.

2.6.Тухайн нутаг дэвсгэрийн албан газар, байгууллагын түлээний модны хэрэгцээг "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 4.7-д заасны дагуу хангана.

2.7.Нутгийн иргэд ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг төлж, цэвэрлэгээний огтлолтоос гарсан модноос түлээний хэрэгцээг хангана.

Гурав . Ойн цэвэрлэгээний огтлолтыг төлөвлөх, зохион байгуулах

3.1.Ойд хийх цэвэрлэгээний огтлолтын талбайн хэмжээг Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2008 оны 89/35 тоот хамтарсан тушаалаар баталсан "Ойжуулалт, ойн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 2 дугаар зүйл мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 127 дугаар тушаалаар баталсан "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 2 дугаар зүйлд зааснаар төлөвлөж, батлуулна.

3.2.ОЙ цэвэрлэж бэлтгэх модны төлбөрийг талбай тусгаарлалтаар тогтоогдсон үнэлгээний дагуу төлнө. Түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойгоос цэвэрлэгээний огтлолтоор хэрэглээний, түлээний мод бэлтгэж ашигласны төлбөрийг Засгийн газрын 2005 оны 147 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад 60 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлнэ.

3.3."Түлээ бэлтгэх эрхийн бичиг"-ийг сумын ойн ангийн дарга эсхүл сумын Засаг даргын томилсон албан тушаалтан "Мод бэлтгэх гэрээ"- г үндэслэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад бичиж олгоно.

3.4. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээний дагуу бэлтгэсэн түлээний модыг Улаанбаатар хот болон өөр аймгуудад тээвэрлэхэд мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг "Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох, тэдгээрийг хэрэглэх, хяналт тавих журам"-ын 5.13-д зааснаар авна.

Дөрөв. Ойд цэвэрлэгээний огтлолг явуулах нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

4.1.Ойд цэвэрлэгээний огтлолт хийх эрх бүхий нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь сум, дүүргийн Засаг даргатай "Мод бэлтгэх гэрээ" байгуулж, ажиллана.

4.2.Мод бэлтгэлийн талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөрийг төлж, "Түлээ бэлтгэх эрхийн бичиг"-ийг авна.

4.3.Ойд цэвэрлэгээний огтлолт хийхдээ мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлтийг мөрдөж ажиллана.

4.4.Ойн цэвэрлэгээний огтлолтоос гарсан модыг тээвэрлэхэд "Ойгоос мод бэлтгэх журам"-ын 5.4-т заасны дагуу хяналтын хуудас хэрэглэнэ.

4.5.Ойн цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн хэрэглээний, түлээний модыг өөр аймаг, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдахдаа гарал үүслийн гэрчилгээг холбогдох газраас авсан байна.

4.6.Ойн цэвэрлэгээний огтлолт явуулсан талбайг мод бэлтгэлийн талбай тусгаарласан материалыг үндэслэн байгаль хамгаалагчид актаар хүлээлгэн өгнө.

Тав. Ойд явуулах цэвэрлэгээний огтлолтын явцад хяналт тавих

5.1.Ойд цэвэрлэгээний огтлолт явуулах ажлын явцад байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч байнгын хяналт тавьж ажиллана.

5.2.Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ойн ангийн мэргэжилтэн ойн цэвэрлэгээний огтлолтын явцад шалгалт хийж, холбогдолтой хууль тогтоомж, журам, зааврыг сурталчлан таниулж, ойн зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

5.3. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойд цэвэрлэгээний огтлолт хийх явцдаа хууль тогтоомж, журам, зааврыг зөрчсөн нь тогтоогдвол байгаль орчны хяналтын улсын байцаагч нь Ойн тухай хууль болон холбогдох хуулийн дагуу Захиргааны шийтгэл ногдуулна.

